“ЧӨЛӨӨЛЬЕ” БОДЛОГЫН ХҮРЭЭНД ХИЙЖ ХЭРЭГЖҮҮЛСЭН АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН

Байгууллагын нэр: **ЭХ ХҮҮХДИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ**

2026.06.18

№	Хэрэгжүүлсэн арга хэмжээ	Үр дүн
ЭДИЙН ЗАСГИЙН ЧӨЛӨӨЛӨЛТ		
1	Банкны өндөр хүүгийн дарамтаас ажилчдаа хамгаалах зорилгоор харилцагч банкуудтай хамтран ажиллах гэрээ байгуулсан.	**Эдийн засгийн чөлөөлөлт 1-ийн хүрээнд:** Тус төвийн 2026 оны батлагдсан орон тоо 1184. 2026 оны 06 сарын 15-ны байдлаар 1080 албан хаагч үүрэг гүйцэтгэж байна. Үүнээс хаан банкаар 408, Худалдаа хөгжлийн банкаар 425, Голомт банкаар 107, Хас банкаар 136, М банкаар 1, Төрийн банкаар 3 ажилтан цалингаа авч байна. 1. **Худалдаа хөгжлийн банк**тай хамтран ажиллах гэрээний хүрээнд бүх төрлийн зээлийг хамгийн таатай нөхцлөөр ажилчдад олгуулж байна. • 1,4%-1,6%-ийн хүүтэй цалингийн зээлд 410 ажилтан хамрагдаж 3.5 тэрбум төгрөг • МИК-ийн 6%-ийн орон сууцны зээлд 86 ажилтан хамрагдаж 7.8 тэрбум, үүнээс 2026 онд 9 ажилтан 1,3 тэрбум шийдэгдсэн, 7 ажилтны 740 сая төгрөгийн зээл шийдэгдэх шатанд байна. • Хадгаламж барьцаалсан зээлд 309 ажилтан хамрагдаж 204.2 сая төгрөг • Хэрэглээний зээлд 12 ажилтан 27.5 сая төгрөг • Автомашины зээлд 1 ажилтан 14 сая төгрөг 2. **Голомт банк**тай хамтран ажиллах хүрээнд: • Цалингийн болон орон сууцны зээлийг 1.2%-ийн хүүтэй олгож байна. • 2026 оны эхний хагас жилд 23 ажилтан цалингийн болон орон сууцны 388 сая төгрөгийн зээлд хамрагдсан байна. 3. **Хаан банкаар** цалингаа авдаг 400 гаруй ажилтны эрх ашгийг хамгаалах, зээлийн хүүгийн дарамтаас гаргах үүднээс тус банкинд хамтран ажиллах тухай албан бичгийг 2025, 2026 онд жил дараалан хүргүүлж, удаа дараа утсаар холбогдсноор 2026 оны 6 дугаар сарын 22-ны өдөр хамтран ажиллах гэрээ байгуулж, цалингийн болон орон сууцны зээлд 1,4% хүүтэй хамрагдах боломжтой боллоо.
2	Бүх төрлийн худалдан авалтыг олон нийтэд	**Эдийн засгийн чөлөөлөлт 2-ын хүрээнд:** Хувийн хэвшил өсөж өндийх, бизнес эрхлэх эрх чөлөө, хөрөнгө оруулалтыг дэмжин тус төвийн бүх худалдан авалтыг олон нийтэд нээлттэй зарлаж,

№	Хэрэгжүүлсэн арга хэмжээ	Үр дүн
	нээлттэй зарлаж, тендер шалгаруулалт хийсэн.	тендер шалгаруулалтын хүрээнд шийдвэрлэдэг бөгөөд төвийн захирал дангаар шийдвэр гаргадаггүй. 2026 оны эхний хагас жилийн байдлаар **20.935.088.770** төгрөгийн худалдан авалтыг хийсэн байна. **1. Нээлттэй тендер шалгаруулалтын аргаар:** • Цэвэрлэгээний материал ханган нийлүүлэх 397.324.000 төгрөг • Нормын хувцас, зөөлөн эдлэл ханган нийлүүлэх 364.949.800 төгрөг • Хүнсний материал ханган нийлүүлэх 1.404.378.900 төгрөг • Эм, эмнэлгийн хэрэгсэл, урвалж бодис ханган нийлүүлэх 15.827.291.322 төгрөг • Багаж, техник хэрэгсэл ханган нийлүүлэх 305.357.100 төгрөг • Өндөр өртөгтэй тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээ үзүүлэх 400.000.000 төгрөг • Эмнэлгийн аюултай хог хаягдлыг тээвэрлэх, устгах ажил гүйцэтгэх 124.000.000 төгрөг **2. Харьцуулалтын аргаар:** • Бичиг хэргийн материал ханган нийлүүлэх 72.826.700 төгрөг • Улсын мэдээллийн маягт ханган нийлүүлэх 35.741.500 төгрөг • Шатахуун ханган нийлүүлэх 50.000.000 төгрөг • Ehealth программын хөгжүүлэх ажил 48.000.000 төгрөг • Амьсгалын аппаратны дагалдах хэрэгсэл худалдан авах 38.990.000 төгрөг **3. Ерөнхий гэрээний аргаар** • Эм, эмнэлгийн хэрэгсэл худалдан авах 1.066.229.448 төгрөг
3	Хуулиас давсан дүрэм, журам гаргахыг таслан зогсоосон.	**Эдийн засгийн чөлөөлөлт 3-ын хүрээнд:** Хуулиас давсан дүрэм, журам гаргахыг таслан зогсоох үүднээс Авлигатай тэмцэх газрын 2026 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн 04/4656 тоот албан бичгийн хүрээнд шинээр болон шинэчлэн боловсруулсан журмыг Авлигатай тэмцэх газарт хүргүүлж, хянуулж байна. 2026 оны эхний хагас жилийн байдлаар 2 журмыг хянуулан, Авлигатай тэмцэх газрын 2026 оны 06 дугаар сарын 11-ний өдрийн 04/8732 тоот албан бичгээр ирүүлсэн зөвлөмжийн дагуу шинэчлэн найруулж ажиллаж байна. **1. Шинээр боловсруулсан журам**

№	Хэрэгжүүлсэн арга хэмжээ	Үр дүн
		“Удирдах албан тушаалтныг сонгон шалгаруулах журам” **2. Шинэчлэн боловсруулсан журам** “ЭХЭМҮТ-ийн албан хаагчдад ажлын гүйцэтгэл, үр дүн, бодит бүтээмжийг үнэлэн улирлын мөнгөн урамшуулал олгох журам”
4	Татвар, шимтгэлээс чөлөөлөх бодлогыг хэрэгжүүлсэн.	**Эдийн засгийн чөлөөлөлт 4-ийн хүрээнд:** Тус төвд хүний нөөцийн хэрэгцээ шаардлагын улмаас түр орон тоонд тэтгэвэр тогтоолгосны дараа гэрээгээр ажиллаж байгаа **135 ажилтан** байна. Үүнээс **68 ажилтны** гаргасан хүсэлтийн дагуу нийгмийн даатгалын шимтгэл төлөлтөөс чөлөөлж, цалин хөлснөөс суутгал хийлгүй олгож байна.
5	Төсвийн зардалыг хэмнэх, цомхон бүтцээр ажиллах хүний нөөцийн менежментийг хэрэгжүүлсэн.	**Эдийн засгийн чөлөөлөлт 5-ын хүрээнд:** 1. Төсвийн зарлагыг эрэлт хэрэгцээ, үр ашгаар нь эрэмбэлж, хэрэгцээ шаардлагагүй зардлуудыг танаж, хэмнэлтийн горимд шилжсэн. 2. Төрийн давхардсан чиг үүргийг цэгцэлж, орон тоог бууруулсан. **2025 онд 1267** албан хаагч ажиллах орон тоог баталсан бол **2026 онд 1184** орон тоог баталсан. Энэ нь орон тоог **6.5% бодитоор бууруулж, 83 орон тоог цомхотгосон** байна. 2026 онд батлагдсан орон тоог авч үзвэл эмч 311, сувилагч 424, эх баригч 86, эмнэлгийн бусад мэргэжилтэн 112, бусад дээд мэргэжилтэн 53, үйлчлэгч 103, бусад ажилтан 95 байна. Үүнийг **“Төрөлжсөн мэргэшлийн эмнэлгийн бүтэц үйл ажиллагаа” MNS 6330:2017 стандарттай** харьцуулан үзвэл эмнэлгийн тусламж үйлчилгээг гардан үзүүлдэг эмнэлгийн мэргэжилтэн, тусламж үйлчилгээг үзүүлэхэд шууд оролцдог эмнэлгийн бусад мэргэжилтэн болон захиргаа, аж ахуйн үйлчилгээний ажилтны харьцаа **74%:26%** байгаа нь стандартын дагуу зохистой харьцааг бүрдүүлсэн байна. **3. Олон жилийн тогтсон хэв маягыг эвдэж, ажлын ачааллыг тэнцвэржүүлж, цомхон бүтцээр үр ашигтай ажиллахаар хүний нөөцийн менежментийн хувьд зоримог, эрс шийдэмгий шийдвэр гаргасан.** • 2026 оны 03 дугаар сарын 01-ний өдрөөс **үйлчлэгч нарыг багийн зохион байгуулалт**ад шилжүүлж шэйрлэж ажиллуулснаар ажлын ачаалал тэнцвэржиж, ажлын гүйцэтгэл сайжирсан. 2025 оны 12 сараас 2026 оны 01, 02 сарын үйлчлэгч нарын илүү цагийн хөлсөнд

<table>
<tr><th>№</th><th>Хэрэгжүүлсэн арга хэмжээ</th><th>Үр дүн</th></tr>
<tr><td></td><td></td><td>
зарцуулсан зардлыг 2026 оны 03,04,05 сарын зардалтай харьцуулж үзэхэд сар бүр 20.000.000 – 30.000.000 төгрөгийн зардал бодитоор буурсан.
<table>
<tr><th>Үзүүлэлт</th><th>2025 оны 12 сар /суурь түвшин/</th><th>2026 оны 4 сар</th><th>2026 оны 5 сар</th></tr>
<tr><td>Илүү цагийн хөлс авсан үйлчлэгчийн тоо</td><td>91</td><td>52</td><td>78</td></tr>
<tr><td>Ажлын өдрийн илүү цаг</td><td>3717</td><td>1080</td><td>1645</td></tr>
<tr><td>Амралтын өдрийн илүү цаг</td><td>359</td><td>0</td><td>14</td></tr>
<tr><td>Нийт илүү цаг</td><td>4076</td><td>1080</td><td>1659</td></tr>
<tr><td>Илүү цагийн хөлсөнд зарцуулсан мөнгө</td><td>41.647.646</td><td>10.354.448</td><td>16.779.300</td></tr>
</table>
Дээрх хүснэгтээс харахад 2025 оны 12 сарын илүү цаг болон илүү цагийн хөлсийг суурь түвшин гэж үзвэл үйлчлэгч нарын ажлыг зөв зохион байгуулж, хүний нөөцийн менежментийг оновчтой хийснээр үйлчлэгч нарын илүү цаг 73%, илүү цагийн хөлс 75%-аар буурч, сар бүр 20-30 сая төгрөгийн зардлыг хэмнэж байна.
Аливаа шинэчлэлийг хийхэд 80%-90%-ийн эсэргүүцэлтэй тулгардаг. Үүний нэгэн адилаар дээрх шинэчлэлийг хийхдээ тулгарсан асуудал, эсэргүүцэл, саад, бэрхшээлийг амжилттай зохицуулснаар 2026 оны 6 сарын байдлаар нэгдсэн зохион байгуулалтад орж, шинэ хөдөлмөр зохион байгуулалтыг үйлчлэгч нар төдийгүй тасаг нэгжийн дарга эрхлэгч нар хүлээн зөвшөөрсөн.
Ийнхүү шинэчлэлийн эсэргүүцлийг амжилттай даван туулснаар манай төвийн цэвэрлэгээ, үйлчилгээний чанар сайжирч, гүйцэтгэл сайжирч, зардал хэмнэгдэж, ажилчдын ажлын ачаалал тэнцвэржсэн.

Хөдөлмөрийн зах зээлд сувилагчийн хүрэлцээ муу, эрэлт өндөр байгаа тул тус төвд дутагдалтай байгаа 90 гаруй сувилагчийн дутагдал хэрэгцээ шаардлагыг нөхөж, эрүүл мэндийн тусламж үйлчилгээг чанартай хүртээмжтэй үзүүлэхээр 2026 оны 05 сарын

</td></tr>
</table>

№	Хэрэгжүүлсэн арга хэмжээ	Үр дүн
		15-ны өдрөөс сувилагч нарыг мөн адил **багийн зохион байгуулалт** шилжүүлэн ажиллуулж байна. Ингэснээр 2026 оны 05 сарын 15-ны өдрөөс өмнөх саруудад **2-2,5 ээлжтэй 3 тасаг байсныг 3 ээлжинд оруулж, 5 тасгийг 4 ээлжээр** ажиллуулж байна. Энэхүү хүний нөөцийн менежментийг хэрэгжүүлснээр сувилагч нарын ачаалал буурч, тусламж үйлчилгээнд учирч болохуйц болзошгүй эрсдэл болон илүү цагийн зардлыг бууруулж байна. Хэрэгжүүлж эхлээд 1 сар болж байгаа тул үйлчлэгчийнхтэй адил тооцоолол хийх боломжгүй байна.
6	МСҮТ-ийн сургалтыг дэмжиж ажилласан.	**Эдийн засгийн чөлөөлөлт 8-ын хүрээнд:** МСҮТ-ийн сургалтын үйл ажиллагааг дэмжих хүрээнд Үйлдвэрлэл урлалын политехник коллежийн 2026 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн 792 тоот албан бичгийн дагуу **мэдээллийн технологийн чиглэлээр суралцаж буй 1 дүгээр курсийн суралцагчдыг 2026 оны 06 дугаар сарын 22-ны өдрөөс 21 хоногийн танилцах дадлагыг** тус төвийн Мэдээллийн технологийн албанд хийлгэхээр төлөвлөн ажиллаж байна. **Эдийн засгийн чөлөөлөлт 6,7-д тусгагдсан асуудал манай төвд хамааралгүй байна.**
ЭРХ ЗҮЙ, ДҮРЭМ ЖУРМЫН ЧӨЛӨӨЛӨЛТ		
.1	Баялаг бүтээгч хувийн хэвшлээ төрийн хүнд зуршлаас чөлөөлөх бодлогыг дэмжсэн.	**Эрх зүй, дүрэм журмын чөлөөлөлт 1-ийн хүрээнд:** Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын гурвалсан гэрээний дагуу өнгөрсөн 2025 оны гэрээг дүгнэн гэрээний сунгалтыг 2026 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс хийсэн. Үүнд: • Кофе шоп-3 • Цайны газар-1 • Эмийн сан-2 Авто зогсоолын тендер шалгаруулалтын нээлттэй зарлаж, 2026 оны 2 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн авто зогсоолын үйл ажиллагааг Өнө мөнх ХХК болон Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газартай гэрээ байгуулан үйл ажиллагаагаа эхлүүлсэн.
2	Эрсдэл багатай, зардал ихтэй ажлыг гэрээгээр гүйцэтгүүлж байна.	**Эрх зүй, дүрэм журмын чөлөөлөлт 2-ын хүрээнд:** 1. 2026 оны 6 сарын байдлаар 70 ажилтанг гэрээтээр ажиллуулж байна. Гэрээт ажилчдад ямар нэг нэмэгдэл өгдөггүй болсон. Энэ нь цалин, нэмэгдлийн зардлыг хэмнэж байна. Үүнд: • Жолооч -1 • Харуул – 4

№	Хэрэгжүүлсэн арга хэмжээ	Үр дүн
		• Машинист -1 • Ачигч-1 • Мужаан -1 • Салхивчны техникч -1 • Үйлчлэгч – 61 2. 2026 оны 01 дүгээр сараас тэтгэвэр тогтоолгосны дараа хүний нөөцийн зайлшгүй хэрэгцээ шаардлагаар түр орон тоонд ажиллаж байгаа нийт 135 эмч, сувилагч, эмнэлгийн мэргэжилтэнтэй харилцан тохиролцож 1 жилийн хугацаатай "Хөлсөөр ажиллах гэрээ" байгуулснаар **төрийн албанд ажилласан жилийн нэмэгдлийг хасаж** тооцон олгодог болсон. Ингэснээр сар бүр олгох байсан **55.568.000 төгрөгийн** зардлыг хэмнэсэн. Үүнд: • 16 эмчийн 8.512.000 төгрөг • 68 сувилагч, эмнэлгийн мэргэжилтний 31.246.000 төгрөг • 51 үйлчлэгч болон бусад ажилтны 15.810.000 төгрөг Эдгээр 135 ажилтантай 1 жилийн гэрээ байгуулсан тул гэрээний хугацаанд хэмнэх зардал ойролцоогоор **666.816.000** төгрөг байна. Цалин үе шаттай нэмэгдэх тул энэхүү тооцоолсон зардлын хэмжээ өссөн дүнгээр бодогдоно. 3. Мөн улирлын үр дүнгийн мөнгөн урамшууллыг тооцож олгох журамд **гэрээгээр ажил гүйцэтгэж байгаа албан хаагчдад өгөхгүй** байх зохицуулалтыг оруулснаар эдгээр 205 ажилчдад олгох байсан 2026 оны 1 дүгээр улирлын урамшуулал 40%-аар тооцвол **123.725.600** төгрөгийн зардлыг хэмнэсэн. • 16 эмчийн 13.619.200 төгрөг • 68 сувилагч, эмнэлгийн мэргэжилтний 49.993.600 төгрөг • 121 үйлчлэгч болон бусад ажилтны 60.112.800 төгрөг
3	Төрийн албан хаагчид ажил хийж, шийдвэр гаргах эрхийг шат шатанд нь шилжүүлсэн.	**Эрх зүй, дүрэм журмын чөлөөлөлт 3-ын хүрээнд:** Хүний нөөцийн менежментийн хувьд байгууллага дотооддоо ижил ажил мэргэжил, албан тушаалын хувьд цалин хөлсийг бууруулахгүйгээр ачааллыг тэнцвэржүүлэх, тусламж үйлчилгээг сайжруулах, албан хаагчдын мэргэжлийн ур чадварыг сайжруулах, тасралтгүй сургаж хөгжүүлэх зорилгоор сэлгэн ажиллуулах бодлогыг хэрэгжүүлж байна. Энэхүү бодлогын хүрээнд асуудал хариуцсан дарга нарт шийдвэр гаргах эрх мэдлийг нь өгч, ажлын

№	Хэрэгжүүлсэн арга хэмжээ	Үр дүн
		гүйцэтгэл, үүрэг даалгаврын биелэлтэд хяналт тавьж, хамтран ажиллаж байна.
4	Харьяалал болон орон зайн байршлаас үл хамааран эрүүл мэндийн тусламж үйлчилгээг түргэн шуурхай, чирэгдэлгүй, чанартай үзүүлж байна.	**Эрх зүй, дүрэм журмын чөлөөлөлт 4-ийн хүрээнд:** Тус төв нь **эх-эмэгтэйчүүд-ураг-нярай-хүүхдийн** эрүүл мэндийн лавлагаа шатлалын тусламж үйлчилгээг улсын хэмжээнд үзүүлж, мэргэжил аргазүйгээр ханган ажилладаг. Манай ЭХЭМҮТ нь хүнд, хүндэрсэн, амь тэнссэн үйлчлүүлэгчийг хүлээн авч, **үнэ төлбөргүй** үйлчилгээ үзүүлдэг онцлогтой. • Тиймээс харьяалал харгалзалгүй ирсэн үйлчлүүлэгч нэг бүрийг хүлээн авч үзэж, шаардлагатай эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, оношилгоо, шинжилгээ, эмчилгээнд хамруулж байна. 2026 оны эхний 5 сарын байдлаар 7399 хүүхэд, 6497 эх, эмэгтэйчүүд нийт 13896 үйлчлүүлэгч хэвтэн эмчлүүлсэн бол 40085 эх, эмэгтэйчүүд, 99147 хүүхэд поликлиникийн үзлэг, оношилгоо эмчилгээнд хамрагдсан байна. • Түүнчлэн газарзүйн байршлаас үл хамааран тус төв нь үзлэг шинжилгээг телемедицинээр үзүүлж байна. 2026 оны эхний хагас жилд 155 удаагийн цахим зөвлөгөө хийж, 153 эх, хүүхдэд эрүүл мэндийн тусламж үзүүлэхэд дэмжлэг үзүүлсэн. • Алсын дуудлагаар хүнд, хүндэрсэн тохиолдолд хөдөө, орон нутагт очиж эмнэлгийн тусламж үйлчилгээг үзүүлдэг. 2026 оны эхний хагас жилд нийт 11 удаагийн алсын дуудлагад явж, 11 үйлчлүүлэгчид лавлагаа шатлалын эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үзүүлсэн. • Төвлөрлийг сааруулах зорилгоор хүүхэд-эх барих эмэгтэйчүүдийн төрөлжсөн мэргэжлийн эмч нарын баг хөдөө орон нутагт очиж лавлагаа шатлалын эрүүл мэндийн тусламж үйлчилгээг 4 (Өмнөговь, Дорноговь аймаг, Мандал, Даланжаргалан, Гурван тэс сумдад) удаа үзүүлж, 1050 үзлэг оношилгоо хийж, 41 хүүхдэд мэс засал эмчилгээ хийсэн байна.
5	Эрүүл мэндийн даатгалын цахим хасагдлыг бууруулах, эмч, сувилагч нарын өвчний түүхийн хөтлөлтийг сайжруулан ажиллаж байна.	**Эрх зүй, дүрэм журмын чөлөөлөлт 5-ын хүрээнд:** ЭХЭМҮТ нь хуулинд заасны дагуу жирэмсэн эх, хүүхэд, нярайн тусламжийг үнэ төлбөргүй үзүүлдэг боловч бусад эмнэлгийн адил гүйцэтгэлээр ЭМД-ийн сангаас санхүүждэг. Манай төвийн санхүүжилтийн 98.1% нь гүйцэтгэлтэй холбоотой. Тиймээс эмч нарын онош, сувилагчийн сувилгааны түүхийн алдааг илрүүлэх, засаж сайжруулах чиглэлээр анхаарал хандуулж, даатгалын эмч нарыг 100% орон тоогоор ажиллуулж байна. Ингэснээр цахим түүхийн хасагдлыг эрс бууруулсан.

<table>
<tr><th>№</th><th>Хэрэгжүүлсэн арга хэмжээ</th><th>Үр дүн</th></tr>
<tr><td></td><td></td><td>• 2024 онд 11.8%
• 2025 онд 4.9%
• 2026 оны эхний хагас жилд 3,8% болж буурсан.</td></tr>
<tr><td colspan="3">НОГООН ХӨГЖЛИЙН ЧӨЛӨӨЛӨЛТ</td></tr>
<tr><td>1</td><td>Ус, дулаан, цахилгааны зохистой хэрэглээг дадал болгохоор санаачлага гаргав.</td><td>2026 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн 10:00 цагт Төвийн нийт 56 тасаг нэгжийн дарга эрхлэгч, ахлах сувилагч, захирал, дэд захирлуудад “Ус дулаан, цахилгааны зохистой хэрэглээ, авч хэрэгжүүлэх арга хэмжээ” сэдэвт хурлыг зохион байгуулж 122 албан хаагч хамрагдав.

Хурлаар Үйл ажиллагаа төлөвлөлт эрхэлсэн дэд захирал Э.Бямбасүрэн 2022-2025 оны ус, дулаан, цахилгааны зардалд зарцуулсан зардлын талаар танилцуулга хийж. Дулааны инженер С.Эрдэнэчимэг ус хангамж, ариутгах татуургын систем, ус, дулаанаа хэрхэн хэмнэх талаар, Цахилгааны инженер Б.Цэнгэлбаатар цахилгаан хангамж, цахилгаан тоног төхөөрөмж, цахилгаанаа хэмнэх арга замын талаар мэдээлэл бэлтгэн танилцуулав.
ЭХ ХҮҮХДИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ
Цахилгаан эрчим хүчний зардал их гарч байгаа нь доорхи хүчин зүйлүүдээс шалтгаалж байна. Үүнд:
-Барилгажилт нэмэгдсэн
-Цахилгаан эрчим хүчний илүүдэл хэрэглээ
-Эмнэлгийн тоног төхөөрөмжийн тоо нэмэгдсэн
- Цахилгаан тоноглолын тоо нэмэгдсэн
-Цахилгаан хангамжийн өртөг нэмэгдсэн
Сүүлийн 4 жилийн цахилгаан эрчим хүчний хэрэглээ ба өртөг тооцсон дүнг жагсаавал:
<table>
<tr><th>Он</th><th>1 Квт/ц-ын өртөг</th><th>ЭХЭМҮТ-ийн хэрэглээ Квт/ц</th><th>Нийт өртөг /төгрөг/</th></tr>
<tr><td>2022</td><td>211</td><td>2,285,700</td><td>666,238,369</td></tr>
<tr><td>2023</td><td>211</td><td>2,715,200</td><td>802,518,636</td></tr>
<tr><td>2024</td><td>211</td><td>3,041,025</td><td>841,999,619</td></tr>
<tr><td>2025</td><td>308</td><td></td><td>1,361,628,520</td></tr>
</table>
Утас 362233, 362205
И-мэйл: ehemut@pcmch.gov.mn
Вэб сайт: www.ehemut.com</td></tr>
</table>

№	Хэрэгжүүлсэн арга хэмжээ	Үр дүн
2	Ус, дулаан, цахилгааны зардлаа хэмнэх зааварчилгаа бэлтгэн хүргэв.	ЭХЭМҮТ-ийн ажилчдын дотоод бүлгэм дээр **"Ус цахилгаанаа хэмнэе"** видео бичлэг бэлтгэн нийт албан хаагчдад уриалга гаргасан.  Тасаг нэгжүүд уриалгыг хэрэгжүүлэн өдрийн цагт байгалийн нарны гэрлийг ашиглан гэрэлтүүлэг сайтай өрөө тасалгааны гэрлийг унтраах, гарч орохдоо гэрлээ унтраах, крантаа бага нээж усаа хэмнэх, суултуурын усаа татахдаа жижиг товчлуурыг ашиглаж бага ус хэрэглэхийг дор бүрнээ анхааран ажиллаж байна.

№	Хэрэгжүүлсэн арга хэмжээ	Үр дүн
3	Санамж боловсруулан гэрлийн унтраалга, крант, 00-ийн өрөөнд байршуулав.	Халаалт ус цахилгаанаа хэмнэе "Санамж" 250 ширхэгийг боловсруулан тасаг нэгжүүдэд байршуулсан.
АВЛИГЫН ЭСРЭГ ЧӨЛӨӨЛӨЛТ		
1	Мэдээллийн ил тод байдлыг ханган ажиллаж байна.	Тус төв нь цахим хуудсаар дамжуулан иргэд, олон нийтэд нээлттэй мэдээллийн ил тод байдлыг сайжруулах чиглэлээр улирал тутам шинжилгээ хийж, дутуу мэдээллийг байршуулж, хяналт тавьж ажиллаж байна. 2025 оны 4 дүгээр улирлын “Шилэн индекс”-ийн үнэлгээг 2026 оны 1 дүгээр улирлын үнэлгээтэй харьцуулж үзвэл мэдээллийн ил тод байдал 8% сайжирсан байна.  
2	Ёс зүйн гэрээ байгуулсан	Албан хаагчдын ёс зүй, сахилга хариуцлагыг сайжруулах үүднээс эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн дүрэм, төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль, ашиг сонирхлоос ангид байх зарчмын хүрээнд ажилчидтай хийх ёс зүйн гэрээг боловсруулан 2026 оны 01 дүгээр сард нийт албан хаагчидтай **анх удаа “Ёс зүйн гэрээ”-г** байгуулсан. Нийт албан хаагчдын хамрагдалт **100%.**

№	Хэрэгжүүлсэн арга хэмжээ	Үр дүн
3	Ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх гэрээ байгуулах, баталгаа гаргуулна.	1. Авлигын эсрэг хууль, нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн хүрээнд “Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх гэрээ”, “Ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх баталгаа” боловсруулсан. **“Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх гэрээ”**-г нийт 56 тасгийн эрхлэгч, албадын дарга нартай байгуулсан. **100%** **2.** “Ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх баталгаа”-г ажилчдаар гаргуулах зорилгоор боловсруулсан ба 2026 оны 3 дугаар улиралд ажилчдад танилцуулж, баталгаа гаргуулахаар төлөвлөсөн.
4	Ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх сургалт зохион байгуулав	2026 оны 04 дүгээр сарын 23-ны өдөр “Удирдах албан тушаалтны сургалт”-ыг зохион байгуулж, сургалтаар төрийн албан хаагчийн ёс зүй, ашиг сонирхлоос ангид байх талаар хууль эрхзүйн мэдлэгийг Хуулийн зөвлөх Ч.Болдбаатар, Хүний нөөцийн албаны дарга, ёс зүйн сургагч багш Б.Мөнхшүр нар хамтран орсон. Сургалтын үед Мэдүүлэг, мэдэгдэл, тайлбар гаргах нийтийн албан тушаалтнуудад зориулсан гарын авлага таралаж, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх гэрээ байгуулсан.
5	АХА тэмцээн зохион байгуулав	2026 оны 5 дугаар сарын 8-ны өдөр Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн салбар хороо, Үйлдвэрчний эвлэлийн хороо, ЭБАТ нар хамтран 110 ажилтанд сургалт орж, АХА тэмцээн зохион байгуулав. Сургалтаар ЭХЭМҮТ-ийн дэргэдэх Эмнэлгийн мэргэжилтний Ёс зүйн салбар хорооны дарга Э.Энхнаран ёс зүйн хичээл, Эрх бүхий албан тушаалтан Б.Мөнхшүр ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлэх талаар хичээл зааж, ҮЭХ асуулт хариултын АХА тэмцээн зохион байгуулав.

№	Хэрэгжүүлсэн арга хэмжээ	Үр дүн
		Тэмцээний ТЭРГҮҮН байранд ЭТТ-ийн инженер Б.Бадамгарав (Өргөмжлөл, 200.000 төгрөг), ДЭД байранд их эмч О.Даваажав (Өргөмжлөл, 100.000 төгрөг), ГУТГААР байранд сувилагч Б.Оюунгэрэл (Өргөмжлөл, 100.000 төгрөг) нар шалгарсан.
6	Удирдлагын зүгээс авлигыг хянах дотоод хяналтын механизм бүрдүүлэх, авлига, ашиг сонирхлын зөрчлийн талаар мэдээлэгчийг хамгаалах, дарамт шахалт үзүүлэхгүй гэдгээ нийт албан хаагчдад илэрхийлж, олон нийтэд энэ тухай мэдээлэхээр бичлэг хийсэн	Тус төвийн захирал Ж.Отгонбаатар нь авлига, ашиг сонирхлоос ангид байхыг уриалсан болон авлига ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх, сэргийлэх зорилгоор ашиг сонирхлын зөрчлийн талаар мэдээлэл өгсөн мэдээлэгчийг хамгаалах, дарамт шахалт үзүүлэхгүй гэдгээ илэрхийлж бичлэг хийлгэсэн. Одоогоор бичлэгийн засварыг хэвлэл мэдээллийн ажилтан Э.Төгөлдөр хийж байна. Бэлэн болмогц төвийн цахим хуудсанд байршуулна. Мөн QR код уншуулан мэдээлэл илгээх, мэдээлэгчийн нууцыг хадгалах, хамгаалах боломжийг бүрдүүлэхээр Мэдээллийн технологийн инженер Ж.Баянсан ажиллаж байна.
7	Албан хаагчдаас авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар санаачилга гаргаж байна.	• 2026 оны 04 дүгээр сарын 23-ны өдөр “Удирдах албан тушаалтны сургалт”-ыг зохион байгуулж, сургалтын үед Хуулийн зөвлөх Ч.Болдбаатар манай төвийн кейс болох фэйсбүүкээр тарсан өвчний түүхийн талаар ярьж холбогдох хууль эрхзүйн асуудлыг танилцуулж, албан хаагчид албаны мэдээллийг хувийн зорилгоор ашиглах, эсхүл бусдад дамжуулах нь авлигын гэмт хэрэг болон зөрчлийн шинжтэй үйлдэл болох талаар тайлбарлан ойлгуулж, тасгийн эрхлэгч, албадын дарга нарт өөрийн удирдлага дор ажилладаг тасгийн албан хаагчдад мэдээлэл өгөхийг зөвлөсөн. • Сургалтын үед Захирал Ж.Отгонбаатар давхар ажил эрхэлж буй албан хаагч заавал ажил олгогчид мэдэгдэх, зөвшөөрөл авах үүрэгтэйг сануулж, улсын эмнэлэгт албан байгууллагын хүсэлтийн дагуу зөвлөхөөр ажиллаж байгаа эмч нараас бусад ***хувийн эмнэлэгт ажлын бус цагаар ажиллаж байгаа хүмүүст зөвшөөрөл өгөхгүй, өгсөн зөвшөөрлөө 2026.06.01-ний өдрөөс цуцалж байна гэдгээ***

№	Хэрэгжүүлсэн арга хэмжээ	Үр дүн
		илэрхийлсэн. Үүнтэй холбоотой тасгийн эрхлэгч, албадын дарга нар санал хэлж, харилцан ярилцаж, хуулийн зөвлөх холбогдох хуулийн хориглох заалтыг танилцуулж, зөвлөгөө өгч ажиллаа. • 2026 оны 3 дугаар улиралд албан хаагчдаас авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар санал асуулга судалгаа авч, судалгааны үр дүнд үндэслэн хариу арга хэмжээ авах, "Ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх баталгаа" гаргуулахаар төлөвлөсөн.
8	Тохиолдлыг шалгаж, холбогдох арга хэмжээ авав	• Тус төвийн эмч Ө.М нэр дээр Засгийн газрын Иргэд олон нийттэй харилцах 11-11 утсаар ирүүлсэн гомдлыг ЭБАТ Б.Мөнхшүр холбогдох хууль дүрмийн хүрээнд судлаж, нягтлан шалгаж, хууль дүрмийг ухуулан таниулж, санаатай болон санамсаргүй гаргасан үйлдэл эс үйлдэхүйн төлөө дахин давтан гаргахгүй байхыг сануулж, Захирлын тушаалаар 3 сар үндсэн цалинг 20% бууруулах сахилгын шийтгэл ногдуулсан. • Тус төвийн нэр бүхий эмч нар /С.А, Ж.Э, Б.М, Т.М, П.Ж/ ажил олгогчид хэлж мэдэгдээгүй, зөвшөөрөл авахгүйгээр ажлын 2 өдөр, ажлын цагаар өөр байгууллагад сургалт зохион байгуулсан зөрчил гаргасныг Удирдах ажилтны шуурхай хурлаар хэлэлцүүлж, гаргасан зөрчилд тайлбар мэдүүлэг өгөх тухай "Мэдэгдэх хуудас" хүргүүлсэн. Нийт албан хаагчдад энэ зөрчлийн талаар танилцуулж, зөрчил гаргахгүй байх үүднээс хуулийн заалтыг танилцуулсан. • Тус төвийн үйлчлүүлэгч Ө.Н-ийн хууль ёсны төлөөлөгч, аав Д.Ө нь өөрийн хүүхдээ ямарч оочир дараалалгүй, зөвхөн түүний хүүд зориулан тусгайлан санал болгосон /7 удаа/ үзлэг, зөвлөгөө, эмчилгээ, оношилгоо бүхий эмнэлгийн тусламж үйлчилгээнд хамруулахаас удаа дараа /10 удаа/ татгалзаж байгаа боловч манай төвийн нэр бүхий эмч нар /О.Т, П.Э, А.О/ болон удирдлагад удаа дараа гомдол гаргаж байгаа асуудлыг 2024 оны 03 дугаар сараас 2026 оны 06 сар хүртэлх хугацаанд үүссэн 287 хуудас баримтыг үндэслэн холбогдох хуулийн хүрээнд дүгнэлт гарган хүүхдийн эрүүл мэндийн байдлыг хувийн ашиг олох зорилгоор зөрчил гаргаж болзошгүй байгаа тухай ЭМЯ-д мэдээлэл хүргүүлэв.

ТАЙЛАН БИЧСЭН: ХҮНИЙ НӨӨЦИЙН АЛБАНЫ ДАРГА Б.МӨНХШҮР